



ХЭНТИЙ АЙМАГ
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 09 өдөр

Дугаар А/190

Өмнөдэлгэр сум

Архи согтууруулах ундаа худалдах,
түүгээр үйлчлэхийг түр хориглох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, аймгийн Засаг даргын 2024 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн А/502 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль зохион байгуулагдаж байгаатай холбогдуулан 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрөөс 2024 оны 10 дугаар сарын 12-ны өдрийг дуусталх хугацаанд архи, согтууруулах ундаа худалдан борлуулах, түүгээр үйлчлэхийг түр зогсоосугай.
2. Захирамжийг хэрэгжүүлж ажиллахыг тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжийн дарга, захирлуудад үүрэг болгосугай.
3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг хэсгийн төлөөлөгч, цагдаагийн ахлах дэслэгч (Б.Тэмүүжин)-д даалгасугай.



Б.ЭРДЭНЭБААТАР